

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Дүүргүүд нийслэлд төвлөрүүлэх төсвийн орлогын биелэлтийг жигд хангаж, ажлаа эрчимжүүлж ажиллах.				
1	<p>Дүүргийн төсвөөс Нийслэлийн төсөвт 2023 оны 3 дугаар сарын байдлаар 28,935.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 28,935.1 төгрөг шилжүүлж 100%-ийн биелэлттэй, 4 дүгээр сарын хуваарийн дагуу татварыг төвлөрүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Татварын өрийн судалгааг төрлөөр нь гарган өмнөх болон тайлант оны өртэй татвар төлөгчдийн имайл хаяг болон утасны дугаарт мэдэгдэл хүргүүлэх, гэрийн хаягийг тодруулж шуудангаар нэхэмжлэл хүргүүлэх, өр барагдуулах нэхэмжлэхийн хугацаанд төлөлт хийгээгүй татвар төлөгчийн арилжааны банкин дахь харилцах дансны гүйлгээг хаах зэрэг арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.</p>		Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэн ажиллана.	90
Үүрэг даалгавар ХОЁР: Хүүхэд, багачуудыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор нийслэлийн хэмжээнд “Хүүхдэд ээлтэй хот” болгох аяныг эхлүүлж зохион байгуулах.				
2	<p>Дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Хүний хөгжлийн бодлоготой уялдуулан хүүхэд, багачуудыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах зорилгоор “Хүүхдэд ээлтэй хот” аяныг 3 үндсэн чиглэлээр зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ “Өдөр тутам хэрэглэгдэх хүмүүжлийн эерэг арга” эцэг эхчүүдэд зориулсан сургалтаар хүүхдийг бие махбодын хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, ямар нэгэн шийтгэлгүй эерэг орчинд өсгөн хүмүүжүүлэхийг аргын 8 бүлэг сургалт ➢ “ХҮҮХЭД ХАМГААЛАЛ-2023” Эрсдэлт нөхцөлд байгаа, эрсдэлт өртөж болзошгүй хараа хяналтгүй болон хараа хяналт сул, гудамжны нөхцөлд амьдарч буй хүүхэд, хөдөлмөр эрхлэгч хүүхдийг илрүүлэн эрсдэлд өртөхөөс сэргийлэн хамгааллын үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх, хяналт тавьж ажиллах зорилго бүхий арга хэмжээ ➢ “Хүүхдэд учирч болох аюул ослоос урьдчилан сэргийлэх нь” Дүүргийн хэмжээн дэх тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн бусад спорт, чөлөөт цагийн цогцолборуудын эрсдэлийг шалгаж холбогдох байгууллагад мэдэгдэн, зөрчлийг арилгуулах, хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулах зэрэг ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 			30
Үүрэг даалгавар ГУРАВ: Газрын зөрчил арилгаж гарааш буулгасан талбайд тохижилтын нээдсэн зураг төслийг боловсруулан баталж, тохижуулах ажлаа эрчимжүүлэх.				

3	<p>Нийслэлийн хэмжээнд 2023 оны газрын зөрчил арилгах арга хэмжээний хүрээнд 12 байршлын 852 м2 төмөр хашаа, хайс, 5 байршилд 29 тоосгон гараашийг буулгахаар бэлтгэл ажлыг хангаад байна.</p> <p>Зөвшөөрөлгүй 29 тоосгон гарааш эзэмшигч нарт 2 удаагийн шаардах хуудсыг 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр, 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд тус тус хүргүүлсэн.</p> <p>Газрын зөрчил арилгаж, газар чөлөөлөх байршлын төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.</p> <p>Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт газрын зөрчил арилгах Дэд ажлын хэсгийг Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/124 дүгээр захирамжаар байгуулсан.</p> <p>Тус ажлын хэсэг иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, авто зам болон явган хүний замыг хааж, зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн барьсан хашаа, хайс, хаалт, автомат хаалт, тусгаарлах шон, гинж, автомашины гарааш, зөөврийн байгууламжийн зөрчлийг арилган газар чөлөөлөх ажлуудыг хийж гүйцэтгэнэ.</p> <p>Тус байршлуудад тохижилтын ажлыг хийж гүйцэтгэхээр зураг төсвийн ажлуудын судалгааг хийж гүйцэтгэн, геодезийн хэмжилтийн ажил хийгдэж байна.</p>			30
<p>Үүрэг даалгавар ДӨРӨВ: Нөөцийн махны үнэ өндөр, мах ховор байгаа талаар иргэдээс гаргаж байгаа гомдол, хүсэлтийг анхаарч ажиллах, махны өргөтгөсөн худалдаа зохион байгуулж, нөөцийн махны чанарт онцгой анхаарч хяналт тавьж ажиллах.</p>				
4	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн мах жижиглэнгээр худалдан борлуулж буй нийт 38 хүнсний дэлгүүрт 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 2.3 тонн махны үлдэгдэлтэй байна. Нөөцийн махны өргөтгөсөн худалдаагаар борлуулагдаж буй хонины гулууз махны хүртээмж муу байгаатай холбогдуулан дараах байршлаар худалдан борлуулж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ 2 дугаар хороо Алтжин Бөмбөгөр худалдааны төвийн гадна талбай ➢ 14 дүгээр хороо Далайхүү худалдааны төвийн гадна талбайд 2023 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 04 дүгээр сарын 28-ны өдрүүдэд нөөцийн махны өргөтгөсөн худалдааг зохион байгуулан ажиллаж байна. <p>Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны даргын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн “Нөөцийн махны борлуулалтад хяналт тавих ажлын удирдамж”-ийн хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, УБЗАА, НМЭГ, НХХААГ-тай хамтран 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс 04 дүгээр сарын 27-ны өдөр хүртэлх хугацаанд дүүргийн нутаг дэвсгэрт нөөцийн мах худалдан борлуулж байгаа нийт 38 хүнсний дэлгүүрт хүнсний аюулгүй байдал, стандартын хэрэгжилтэд хяналт хийж, иргэдээс гаргасан гомдол, зөрчлийг арилгуулан ажилласан.</p>			100
<p>Үүрэг даалгавар ТАВ: Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан өргөдөл, гомдол, албан бичгийг хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх, хариуцлагагүй хандсан албан хаагч болон удирдлагад хариуцлага тооцож ажиллах.</p>				
5	<p>Дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт 2023 оны 01 дүгээр сарын 02-ноос 04 дүгээр сарын 27-ны өдрүүдэд нийт 1181 өргөдөл ирснээс:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэгдсэн-4 ➢ Өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хугацаанд нь шийдвэрлэн иргэнд хариуг хүргүүлсэн-1062 ➢ Өргөдөл, хүсэлт судлагдаж буй 115 байна. 			90

	<p>Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол санал хүсэлтийг төрлөөр ангилан авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Хүсэлт – 725 ➤ Гомдол -356 ➤ Талархал -67 ➤ Санал -12 ➤ Мэдэгдэл 2 байна. <p>Нийслэлийн хэмжээнд өргөдөл, гомдлыг барагдуулах дундаж хугацааг 9 хоногт хүргэх зорилтын хүрээнд дүүргийн дэргэдэх хэлтэс, албад болон Засаг даргын Тамгын газар, хороодод иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх дундаж хугацаа 7 хоног 03 цаг 27 минут байна.</p> <p>Өргөдөл, гомдлыг шийдвэрлэхдээ иргэнд хариу өгсөн хэлбэрээр нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Иргэний талд шийдвэрлэсэн 852 ➤ Боломжгүй тухай хариу өгсөн 182, ➤ Бусад хариу өгсөн 25 өргөдөл, гомдол тус тус байна. <p>Нутгийн захиргааны байгууллагад хандаж гаргасан өргөдлөөс хамгийн их хандалттайг авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Санхүү, татварын тухай-273 буюу 23.95% ➤ Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны тухай -65 буюу 5.7 % ➤ Нийтийн эзэмшлийн гудамж талбайн болон ТҮЦ, ил задгай худалдааны тухай 52 буюу 4,56%-ийг тус тус эзэлж байна. <p>Дүүргийн хэмжээнд нийт 273 зөрчил тооцогдсоноос:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил–187 ➤ Өдөрт нь багтаан шилжүүлээгүй зөрчил –41 ➤ Явцын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил–44 ➤ Бусад зөрчил-1 байна. <p>Дүүргийн хэмжээнд хамгийн их өргөдөл гомдлын зөрчил гаргаж байгаа байгууллагууд болох Дүүргийн Боловсролын хэлтэс, Дүүргийн Татварын хэлтэс, Дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсүүдэд хариуцлага тооцон хариу ирүүлэх тухай Засаг даргын Тамгын газрын даргын 3/683, 3/684, 3/685 дугаарын албан бичгүүдээр хүргүүлсэн. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дэлгэрэнгүй тайлан, хугацааны тайлан, хандалтын тайланг 14 хоногоор гаргаж Засаг даргын Тамгын газрын даргад болон танилцуулан ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг даалгавар ЗУРГАА: <i>Нийслэлийн хэмжээнд орон сууцны зориулалтай барилгын 1 давхрыг өргөтгөөд үйл ажиллагаа, үйлчилгээ үзүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын барилга, байгууламжид газар хөдлөлт холбоотой эрсдэлийн үнэлгээ хийлгүүлж, цаашид арга зүйгээр хангах, зөвлөн туслах, хэрэгжилтэд хяналт тавьж</i></p>				
6	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсээс нутаг дэвсгэрт нийтийн зориулалттай орон сууцны зориулалт, төлөвлөлтийг өөрчлөн худалдаа, үйлчилгээ эрхэлж буй нийт 379 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гарган 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэст хүргүүлэн ажилласан.</p>			30

<p>Дүүргийн Онцгой байдлын хэлтсээс орон сууцны зориулалтай барилгын 1 давхрыг өргөтгөн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын судалгааг гарган, судалгаагаар нийт 599 байгууллага иргэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ 1 хороонд-93 ➤ 2 хороонд-94 ➤ 3 хороонд-95 ➤ 4 хороонд-216 ➤ 5 хороонд-52 ➤ 6 хороонд-49 аж ахуйн нэгж, иргэн байна. <p>Цаашид тухайн 599 аж ахуйн нэгжид үнэлгээний ямар аргачлал болон хэрхэн үнэлгээг зохион байгуулж ажиллах талаар нийслэлийн Онцгой байдлын газраас өгөгдсөн чиглэлийн дагуу зохион байгуулан ажиллана.</p>			
------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--	--	--

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ